



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/64/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033

Цахим хаяг: Narmandakh.ts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805

Цахим хаяг: Erdene.b@audit.gov.mn

Аудитор: О.Гантуяа

Утас: 70357955

Цахим хаяг: Gantuya.o@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	Error! Bookmark not defined.
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	Error! Bookmark not defined.
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	Error! Bookmark not defined.
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Error! Bookmark not defined.
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	Error! Bookmark not defined.
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан	5
3.1. Ерөнхий зүйл.....	5
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	5
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	5
3.4. Материаллаг байдал	5
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	7
3.7. Шилэн дансны мэдээлэл	7
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
3.9. Аудитын илрүүлэлт	8
Залруулсан алдаа	
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	8
Аудитын зөвлөмж.....	
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	8
4. Менежментийн захидал	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	Error! Bookmark not defined.

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021. 02. 25 № 57
танай _____ -ны № _____ -г

ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Д.Эрдэнэцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд эд хариуцагчийн картыг анхан шатны батлагдсан маягтаар хөтлөх, эд хариуцагч солигдоход тооллого хийж баталгаажуулж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Эрдэнэ, аудитор О.Гантуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ны өдрийн 36 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Аймаг орон нутгийн эдийн засаг нийгмийн үйл ажиллагааны чигийг тогтоож, удирдан зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймгийн ИТХ-ын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Орхон аймгийн ИТХ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 118,565.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,185.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол, гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн (ОРА-2021/64/СТА-ТШЗ)

санхүүгийн тайлангийн нийт орлого 1,871,419.3 мянган төгрөг болж өөрчлөгдсөн тул 1 хувиар буюу 18,714.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,866.5 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	23,301.1	39,214.4	15,913.3
Үндсэн хөрөнгө	161,330.7	157,283.9	-4,046.8
Нийт хөрөнгө	184,631.8	196,498.3	11,866.5
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	184,631.8	196,498.3	11,866.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	184,631.8	196,498.3	11,866.5

Мөнгөн хөрөнгө, авлага болон урьдчилгаа дансанд үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 39,214.4 мянган төгрөг болж 15,913.3 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын дансны үлдэгдлээс шалтгаалжээ. Энэ нь ЗДТГ-аас шилжүүлгээр ирсэн бэлэг дурсгалын зүйлс 49,488.3 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалуудыг бараа материал дансанд орлого авч үлдэгдлээр үлдсэн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал бүртгэгдээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 157,283.9 мянган төгрөг болж тайлант оны 4,046.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан байна. Үндсэн хөрөнгийн дансанд өөрийн хөрөнгөөр 5,599.4 мянган төгрөгийн 2 зөөврийн компьютер, 6910.7 мянган төгрөгийн архивын шүүгээг худалдан авсан байна. Аймгийн орон нутгийн өмчийн газраас 15,190.1 мянган төгрөгийн гараж, Байгаль орчин аялал жуулчлалын газраас 30,000.0 мянган төгрөгийн авто машиныг шилжүүлэн авч орлогод бүртгэсэн байна.

2020 оны санхүүгийн тайланд биет бус хөрөнгө, өр төлбөр дансанд урт болон богино хугацаат өр төлбөр бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 196,498.3 мянган төгрөг болж тайлант оны үр дүн 11,866.5 мянган төгрөгөөр өссөн байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 665,507.0 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 1,350,333.9 мянган төгрөгөөр буюу 19.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин 14,760.4 мянган төгрөг, НДШ 2,303.5 мянган төгрөгөөр зардлууд өссөн байна. Энэ нь МУ-ын засгийн газрын 2019 оны 12 сарын 25-ны өдрийн Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай

472 дугаар тогтоолын дагуу 2020 оны 01 сараас цалин нэмэгдсэн, мөн бүтэц орон тоо өөрчлөгдөж 2 орон тоо нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт, нягтлан бодох бүртгэлийн залруулга бүртгэгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжих 986,349.5 мянган төгрөг, нийт зарлагыг 986,349.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 24,097.9 мянган төгрөгөөр өсгөж нийт зардлыг 1,010,447.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,010,447.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,010,447.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,010,447.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 941,816.9 мянган төгрөгийг зарцуулж, 68,630.4 мянган төгрөгийн зардлын хэмнэлтийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын хэмнэлт 68,630.4 мянган төгрөг буюу 7.2 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 6,157.8 мянган төгрөг, НДШ-ийн зардлыг 1.5 мянган төгрөг, томилолтын зардал 26,111.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 16,968.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 19,390.9 мянган төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд цагаатгалын нөхөн олговрын 762,000.0 мянган төгрөг, аймгийн ОНХСангаас аймгийн наадмын зардлын 5000.0 мянган төгрөг нийт 767,000.0 мянган төгрөгийн орлого орсон байна. Үүнээс улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж цагаатгагдсан 17 иргэдэд 762,000.0 мянган төгрөгийн нөхөн олговор олгосон байна. Аймгийн наадмын зардалд 5,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 136 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 11 мэдээлэл, 5 сая төгрөгөөс (ОРА-2021/64/СТА-ТШЗ)

дээш 1,038,904.7 мянган төгрөгийн 11 орлогын, 467,265.7 мянган төгрөгийн 31 зарлагын, 21,737.5 мянган төгрөгийн худалдан авалтын 12 гүйлгээг мэдээллэсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1		1				
Албан шаардлага							
Зөвлөмж	1		1				
Нийт дүн	2		2				

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 49,493.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 49,400.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 93.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Орлого үр дүнгийн тайланд тусгай зориулалтын бараа материалаас 49,400.7 мянган төгрөгийн шагнал, дурсгалын зүйлийг зарлагадахдаа хөрөнгийн данс сонгож буруу бүртгэснийг тус тус залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 93.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 93.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Аймгийн ЗДТГ-ын мэдээлэл технологийн ажилтанг үндсэн ажлынхаа зэрэгцээ АИТХ-ын мэдээлэл технологийн асуудал хариуцсан ажилтаны үүргийг хавсруулан гүйцэтгүүлж унаа хоолны зардал 93.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Нийгмийн бүлэгт чиглэсэн дэмжлэгийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Нягтлан бодох бүртгэл, бодлогын үйл ажиллагаа

1.1. Илрүүлэлт:

ИТХ-ын даргын 2020.11.11-ны өдрийн Б/05 захирамжаар Д.Жигжидсүрэнг няравын ажлаас чөлөөлж, Ч.Мөнхнаранг няраваар томилж, эд хариуцагч солигдоход хөрөнгийн тооллого хийж баримтжуулаагүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-т “хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ. 12.2.2-т эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед” гэсэн заалтыг хэрэгжүүлж хөрөнгийн тооллого, тооцоог хийж баримтжуулж байх.

Хууль эрх зүйн орчинтой холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны мэдээллийн нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрт ашиг сонирхлын мэдүүлэг гаргаж мэдээлээгүй, 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.2 Эрсдэл:

Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх

Өгсөн зөвлөмж:

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д "Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана" гэсэн заалтыг хэрэгжүүлж, тогтоосон хугацаанд мэдээллийг бүрэн мэдээлж байх.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Орхон аймгийн ИТХ-д өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар 2021.02.25-ны тоот албан бичгээр хариуг ирүүлж, хүлээн зөвшөөрсөн болно.

Орхон аймгийн ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Б.ЭРДЭНЭ

О.ГАНТУЯА

Огноо:

Огноо:

Орхон аймгийн ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021	Аудитын нэр: Орхон аймгийн ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/64/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	ИТХ-ын даргын 2020.11.11-ны өдрийн Б/05 захирамжаар Д.Жигжидсүрэнг няравын ажлаас чөлөөлж, Ч.Мөнхнаранг няраваар томилж, эд хариуцагч солигдоход хөрөнгийн тооллого, тооцоо хийж баримтжуулаагүй байна.		Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Д.Эрдэнэцэцэг С.Халиун
2	Шилэн дансны мэдээлэлийн нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрт ашиг сонирхлын мэдүүлэг гаргаж мэдээлээгүй, 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.		Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Д.Эрдэнэцэцэг С.Халиун
3	Аймгийн ЗДТГ-ын мэдээлэл технологийн ажилтанг үндсэн ажлынхаа зэрэгцээ АИТХ-ын мэдээлэл технологийн асуудал хариуцсан ажилтаны үүргийг хавсруулан гүйцэтгүүлж унаа хоолны зардал 93.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.	93.0	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Д.Эрдэнэцэцэг С.Халиун
ДҮН		93.0			

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР

(ОРА-2021/64/СТА-ТШЗ)

АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТЫГ

Ц.НАРМАНДАХ

Огноо:

Б.ЭРДЭНЭ

Огноо:

О.ГАНТУЯА

10



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 30/30 ОРА-2021/64/СТА-ТШЗ

Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн ЗДТГ-ын мэдээлэл технологийн албан хаагчийг үндсэн ажлынх нь зэрэгцээ АИТХ-ын мэдээлэл технологийн асуудал хариуцсан ажилтны үүргийг хавсруулан гүйцэтгүүлж, унаа хоолны зардал 93.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13.1-т "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Хоол унааны зардал давхардуулан олгосон 93.0 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Орхон аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Эрдэнэцэцэг, нягтлан бодогч С.Халиун нарт хариуцуулав.

¹ Монгол Улс, Орхон аймаг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР..... О.ГАНТУЯА